

МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 1/217

Номгон

Засаг даргын нэрэмжит “Сорил-2023” шалгалт зохион байгуулах зардал олгох тухай

Бүрэн дунд боловсрол эзэмшигчдийн сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах, элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Ковидын дараах сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөө батлах” 8/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн сурагчдаас авах аймгийн Засаг даргын нэрэмжит “Сорил-2023” шалгалтыг 2022 оны 04 дүгээр сарын 22,23 -ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2.Шалгалтыг хугацаанд нь чанартай зохион байгуулж дүн мэдээг үнэн зөв гаргаж тайлагнахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг), Ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус үүрэг болгосугай.

3.Засаг даргын нэрэмжит “Сорил -2023” шалгалтын төсвийг хавсралтаар баталж, 3,132,000 (Гурван сая нэг зуун гучин хоёр мянган) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310545



Аймгийн Засаг даргын 2023 оны 034 дүгээр сарын 11 нийгдрийн 117 дугаар захирамжийн хавсралт

ЗАСАГ ДАРГЫН НЭРЭМЖИТ "СОРИЛ-2023" ШАЛГАЛТЫН ТӨСӨВ

№	Зардлын нэр, төрөл	Шалгуур үзүүлэлт	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	Болзол хангасан сурагчдын урамшуулал	50 /1-р нөхцөл/	50	30000	1,500,000
		10 /2 ба 3-р нөхцөл/	10	100000	1,000,000
2	Сэдэв, хариултын хуудас хэвлэх цаас	A4 хэмжээний бичгийн цаас /боодол/	16	22000	352,000
3	Каноны хор	Херок-work Centre 3345" маркийн канон, принтер	2	140,000	280,000
Бүгд Гурван сая нэг зуун гучин хоёр мянган төгрөг					3,132,000

-----oOo-----